

**Петро Матад Лимитэд (“Петро Матад” эсвэл “Компани” гэх)
Үйл Ажиллагааны Талаархи Шинэчилсэн Мэдээ**

Петро Матад (AIM:MATD) нь Монгол орны зүүн хэсэгт байрлах Матад ХХ талбайн Давсан Толгойн Хэтийн төлөв сайтай талбай дахь өрөмдлөгийн үйл ажиллагааныхаа талаархи шинэчилсэн мэдээллийг үргэж байгаад аа таатай байна.

ДТ-5 цооногийг газрын гадаргаас доош 1,954 метрийнүнд хүртэл өрөмдөж, 2011 оны 06-р сарын 02-ны өдөр дуусгалаа. Цооногийн к аротажийн бичиглэлийг хийж дуусган бичиглэлд петрофизикийн үнэлгээ хийсэн. Өрөмдлөгөөр хөдөлгөөнт нүүрсустөрөгчийн хэд хэдэн нимгэн үеүүд тогтоогдсон бөгөөд тэдгээр нь цооногийн 1,707 метрт буюу Доод Цагаанцавын формацийн дээд хэсэгт нийт 3 метрийн зузаантай юм. Эдгээр үеүүдэд туршилт хийгдэх болно.

ДТ-5 цооногийг Өвгөн Голын эртний голын хөндийн нэг хэсэг болон түүний доор орших Доод Цагаанцавын формацийг судлах зорилгоор өрөмдөж буй талаар бид 2011 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн мэдээлэлдээ дурдсан билээ. Тус цооног нь эртний голын хөндий оршин байгааг, мөн ямар хэлбэрээр оршиж буйг тогтоосон боловч Өвгөн Голын хурдас нь агуулагч давхарга болж чадахгүй занар, нягтрал ихтэй элсэн чулуунаас бүрдсэн болохыг тогтоолоо. 1,707 метрийн үн дэх тост үе нь Өвгөн голын хурдасаас доор орших Доод Цагаанцавын элсэн чулуулагт тогтоогдсон болно.

Өрөмдлөгийн явцад газрын тосны илрэл ажиглагдаагүй бөгөөд тус цооногийн Цагаанцавын формацийн хэмжээндүж сүвшил , нэвчүүлэмж бага байгааг петрофизикийн шинжилгээний үр дүн харууллаа. Бид тус цооногийг 2011 онд багтааж турших бөгөөд тосны урсгалыг эрчимжлэхийн тулд цооногт хагалбарын ажил гүйцэтгэх шаардлагатай хэмээн үзэж байгаа тул хагалбарын ажлыг Ди Кью И Интернэшнл компаниар хийлгэхээр гэрээг боловсруулж байна.

Өрмийг ДТ-1 цооногоос зүүн урд зүгт ойролцоогоор 2.3 км-ийн зайд байрлах ДТ-6 цооног руу үлгэж байна. ДТ-6 цооногийн геологийн даалгавар нь зүүн хойшоо чиглэлтэй, нарийвчлан тодорхойлогдсон эртний голын хөндийн доторхи Дээд Цагаанцав формацийн дээр ялгасан зузаан хэсэг (Өвгөн Гол) болон түүний доор орших Доод Цагаанцавын формаци болно.

Петро Матадын Ерөнхий Гүйцэтгэх Захирал Даглас МакГей хэлэхдээ “Давсан Толгойд хэрэгжүүлж буй манай өрөмдлөгийн хөтөлбөр эерэг үр дүн үзүүлж, бидний өрөмдсөн 5 цооног тус бүрт туршиж, судлах боломжтой үеүүд тогтоогдсоор байгаад баяртай байна. ДТ-5 цооногийн урьдчилсан үр дүнгээр Доод Цагаанцавын формацид нүүрсустөрөгч байгааг харуулсан ба ДТ-1 болон ДТ-2 цооногууд дахь Өвгөн голын эртний хөнд ийн нүх сүвшил, нэвчүүлэмжийн үзүүлэлт өндөр байгаа бол ДТ-5 цооногийн нүх сүвшил, нэвчүүлэмжийн үзүүлэлт бага бага буюу ялгаатай байна.

Тамсагийн Сав газар дахь агуулагч давхаргууд нэгд ижил төрлийнх биш болох нь Дачин Ойлфийлдс компанийн үйл ажиллагаа явуулж буй Тосон Уул XIX талбайд батлагдсан бөгөөд хайгуулын шатанд манай цооногуудын үр дүн харилцан адилгүй байх нь тодорхой байсан. Доод Цагаанцав формацид нүүрсустөрөгч илэрсэн нь цаашид нүүрсустөрөгчийн илрэлийг таамаглахад хялбар болж байгаад таатай байна.”

Энэхүү шинэчилсэн мэдээнд агуулагдсан техникийн мэдээллийг Компанийн Ерөнхий Геофизикч Доктор Күрт Констениус хянасан болно. Доктор Констениус нь Хойд Америк, олон улсын газрын тосны хайгуул, ашиглалтын чиглэлээр 30 жил ажилласан туршлагатай геофизикч бөгөөд газрын тосны геологич. Тэрээр Америкийн Газрын Тосны Геологичдын Холбоо болон Америкийн Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

Петро Матад Лимитедийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай үбээгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 км² талбай бүхий газрын тосны Матад ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол орны төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 км² талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Айл эф Мэн (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспет Хилл, Дуглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.

Нэмэлт мэдээллийг:

Петро Матад Лимитед
Ерөнхий Гүйцэтгэх Захирал – Дуглас Жэй МакГей (Douglas J. McGay)
+976 11 331099

Уэстхауз Секьюритиз Лимитед
Ричард Бэри/Питр Нортон (Richard Baty/Petre Norton)
+44 (0)20 7601 6100